МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,112.513.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.10.27. Пүрэв. №192 (4562) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

АХМАДУУДАД ЖИЛД ХОЁР УДАА 100-300 МЯНГАН ТӨГРӨГ ОЛГОХ НЬ

II нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

V нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




Дугаарын 60 мөр

## Сонгуулийн хуулиа чангалаад юу өөрчлөгдөв

Н.ПУНЦАГБОЛД

2016 оны сонгуулийн өмнө эрх баригчид сонгуулийн хуулийг айхтар чангалсан. Нэр дэвшиж байгаа хүмүүсийн тараах материалыг хэдхэн хэвлэлийн хуудас байна гэж зааж өгсөн. Элдэв сурталчилаа хийж, урлагийн тоглолтоор иргэдийг баярлуулахыг хорьсон. Ер нь сонгуулийн үеэр болох юм ширхэг ч байгаагүй. Тэр ч битгий хэл өдөр тутмын сонинуудыг ч сонгуулийн сурталчилгаанд оролцох боломжийг боомилсон. Нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө хэдхэн хуудас материал дээр хэвлэж тараагаад, хэдхэн самбар байрлуулаад өрсөлдсөн. Ерөөсөө шинэ хүн олонд танигдаж гарч ирэх боломжийг хаах гэж оролдсон л арга шүү дээ. Дээрээс нь сонгуулийн үеэр хууль зөрчиж сурталчилгаа хийх, мөнгө тараах энэ тэр асуудал гаргавал бараг л "цаазаар авах" ухааны л юм яриад байсан. Гэтэл тэр чанга хууль нь зөвхөн хэвлэлийг боомилоход л чиглэсэн юм уу, хаашаа юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

## БЯЛДУУЧИД НЬ ШИЛ, АМИА ХИЧЭЭГСЭД НЬ ХИЛ, ЛИДЕРҮҮД НЬ ФРАКЦИ ДАВСАН АН




Ч.ЧУЛУУН

Ардчилсан намын нэр хүндийн уналт зарим талаар хэн нь хэн байсныг нийгэмд ил тод болгож өгч байх шиг байна. УИХ-ын сонгуульд ялагдал хүлээж, олон арван мянган гишүүд нь намын харьяалал нэрийн дор ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж эхэлсэн тэр өдрүүдэд амин хувиа хичээгсэд нь ном сурах, биеэ эмчлүүлэх нэрийдлээр харийн нутаг руу зорьцгоосон нь нууц биш. Зарим нь өглөө виз мэдүүлээд үүр шөнийн заагаар хилийн дээс алхсан нь ч бий. Дөрөвхөн жилийн өмнө тэд Ардчилсан намын цэнхэр тугийн намираан дор мандан бадарч, төрийн өндөр дээд албан тушаалд заларч байсан санагдана.

**Үргэлжлэл нь III нүүрт**

МЭДЭЭЛЭЛ

## Н.ДАШДАВАА: "Эрдэнэт"-ийн 49 хувь Монголынх болсон нь үндэсний эрх ашигт нийцсэн

Б.ДАВАА

Сүүлийн үед "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг Монголын талд худалдан авсан хийгээд нүүрсний үнэ, Тавантолгойн төмөр замын бүтээн байгуулалтын талаархи асуудлууд олны анхаарлын төвд байх болсон. Тэгвэл эдгээр асуудалтай холбогдуулан Монголын Консерватив намын дарга Н.Дашдаваа өчигдөр "Монгол ньюс" мэдээллийн төвд хэвлэлийн хурал зарлаж, байр сууриа илэрхийллээ. Тэрбээр хэвлэлийн хурлын эхэнд Тавантолгойн гэрээний улмаас Монголын тал ихээхэн хэмжээний хохирол амсч буйг онцолсон юм. Энэ талаар "2010 онд Чалко компанитай нэг тонн нүүрсийг 70 ам.доллароор нийлүүлэх гэрээ байгуулахдаа 350 сая ам.долларыг урьдчилгаа болгон зээл, сонгуулийн өмнө ард түмэнд тараасан. Үүний дараа дэлхийн зах зээл дэх нүүрсний үнэ унасан нэрийдлээр "Чалко"-гийн шахалтаар 23 ам.доллар болгож огцом бууруулсан. Одоо дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ 250 ам.долларт хүрчихлээ. Цаашдаа ч өсөх хандлагатай байгаа. Харин бид 27 ам.доллароор нийлүүлсээр байна. Энэ үнийг өсгөхгүй энэ чигээр нь нийлүүлэлт хийсээр байгаа нь хэн гэдэг улстөрчдөд ашигтай вэ.

**Үргэлжлэл нь II нүүрт**

## МЭДЭГДЭЛ

Ардчилсан нам иргэдийн сонгох, сонгогдох эрхийг ямагт хүндэтгэж ардчилсан сонгуулийн зарчимд үнэнч байж ирсэн. Бид сонгуулийн үр дүнг МАН шиг "хүлээн зөвшөөрөхгүй" хэмээн мэдэгдэж байгаагүй.

Ардчилсан нам Улсын их хурал болон аймаг, Нийслэл Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуулийн дараа эрх баригч МАН-ын зүгээс сонгуулийн амлалтаасаа буцаж, /Ахмадын хамтын тэтгэвэр, хүүхдийн мөнгө, 36 сарын тэтгэмж, оюутны тэтгэлэг 70.000, хүүхэд харах үйлчилгээ, гэр хорооллын дахин төлөвлөлт, сайн хашаа, төрийн албан хаагчдыг хоморголон халсан гэх мэт/ урьдах бүхнээ үгүйсгэхэд хүлээцтэй хандаж ирсэн. Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуулийн үеэр эрх баригчдын зүгээс гаргасан хууль бус үйлдлүүд нь ардчилал, хүний эрх, эрх чөлөөг боомилсон цаашид буруу жишиг тогтоох ноцтой үр дагаварыг бий болголоо гэж Нийслэлийн Ардчилсан нам дүгнэж байна.

Сонгуулийн хороо, санал авах байрны ажилтнуудыг томилохдоо эрх баригчид урьд нь сургалтанд сууж сертификат аван Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн албан хаагчдаас бус хууль зөрчин өөрийн хүмүүсийг томилсон нь сонгуулийг будлиантуулахаар эртнээс төлөвлөсөн ажиллагаа байжээ гэж бид үзэж байна.

Ихэнхи сум, дүүрэгт ИТХ-ын сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигчдийг бүртгэхгүй хасч, зарим газар өрсөлдөгчгүй сонгууль болсон нь иргэний сонгогдох эрх, сонгогчдын сонгох эрхийг бүдүүлгээр хаасан хууль бус үйлдэл гэж Нийслэлийн ардчилсан нам үзэж байна.

Сонгуулийн үр дүнгээр Ардчилсан нам ялалт байгуулсан Баянзүрх дүүрэгт ард түмнээс сонгогдсон 6 нэр дэвшигчийг хууль бусаар хассан үйлдэл нь Монгол улсын сонгуулийн 26 жилийн түүхэнд гарч байгаагүй бусармаг явдал болж, сонгуулийн ардчиллыг үгүй хийн, төрийн эрхийг хууль бусаар авах гэсэн үйл ажиллагаагаа даруйхан зогсоохыг МАН-аас Нийслэлийн Ардчилсан нам шаардаж байна.

Ард түмний сонголтыг үгүйсгэсэн хууль бус энэ үйлдлийн хажуугаар дуугүй өнгөрвөл маргааш таны эрх, эрх чөлөө ч байхгүй болно гэдгийг нийт иргэддээ анхааруулж байна.

Учир иймд Нийслэлийн Ардчилсан нам цаашид эрх баригчдын хууль бус үйлдлүүдийг тэвчихгүй бөгөөд ялангуяа, хувь хүний үндсэн эрхийн төлөө иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, тэмцэхээ мэдэгдэж байна.

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА
ЭРДЭНИЙН БАТ-ҮҮЛ
2016 оны 10 дугаар сар 26

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМ

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

## Н.УЧРАЛ: МОНГОЛЧУУДАД ОЮУНЫ ЭКСПОРТ ХИЙХ БОЛОМЖ БАЙНА

Ж.ОТГОН

*УИХ-ын гишүүн Н.Учралтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

**-УИХ-ын намрын чуулганы завсарлага өндөрлөж, гишүүд ажилдаа орлоо. Та бүхний өмнө нэн тэргүүнд ирэх оны төсвийн тодотголыг хэлэлцэн батлах чухал ажил хүлээгдэж байна. Ер нь ирэх оны төсвийн төсөл хэр бодитой болсон гэж харж байна вэ?**

- Шинжлэх ухаан технологийн хөгжлийн өнөө үед төсвийн зарлагыг хэмнэхдээ ганц нэг зардлыг хасах замаар шийдэхэд хүндрэлтэй. Нэгэнт тогтоогоод мөрдөөд эхэлсэн нэмэлт зардал, хангамж, халамжийг бууруулахад заавал эсэргүүцэлтэй тулгарна. Төсвийн зарлагын хэмнэлт гаргах гэвэл үр ашиггүй зардлыг хасахаас гадна бүтцийн чанартай арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Татвар төлөгчдийн мөнгийг дураар зарцуулах бус норм, хэм хэмжээтэй байх ёстой. Ямар ч бүтээгдэхүүн өөрийн гэсэн норм стандарттай байдгийн адил төсвийн зарлага норм норматив дээр тогтдог гэдгийг анхаарах ёстой. Миний бодлоор энэ удаагийн төсөв зарим зүйл дээр үнэхээр хэцүүхэн байгаа. Маш жижигхэн жишээ дурдахад бие тамир уралдаан, тэмцээний зардалд 62 хүны орон тоотой байгууллага 10 сая төгрөг тусгасан байхад 526 хүний орон тоотой байгууллага 7.7 сая төгрөг тусгасан байсан. Тиймээс цаашдаа төрийн албан хаагчдыг ажлаар нь ялгаварлахгүй байх, нормативыг зайлшгүй тогтоож өгөх нь нэн шаардлагатай юм байна гэдэг зүйл ажиглагдаж байгаа юм.

**Үргэлжлэл нь IV нүүрт**




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2340.00 | 2353.00 | ФУНТ | 2801.00 | 2916.00 |
| ЕВРО | 2520.00 | 2603.00 | РУБЛЬ | 36.10 | 39.40 |
| ИЕН | 22.23 | 22.93 | ЮАНЬ | 344.50 | 348.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2339.00 | 2355.00 | ФУНТ | 2826.00 | 2926.00 |
| ЕВРО | 2526.00 | 2616.00 | РУБЛЬ | 36.40 | 39.96 |
| ИЕН | 22.21 | 23.06 | ЮАНЬ | 345.00 | 349.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ЗАСГИЙН ГАЗАР

# АХМАДУУДАД ЖИЛД ХОЁР УДАА 100-300 МЯНГАН ТӨГРӨГ ОЛГОХ НЬ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Ж.МЯГМАР

*Засгийн газрын хуралдаанаар ахмад настан, алдар цолтнуудад нэмэгдэл, хөнгөлөлт олгох, үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэдэг явдлыг таслан зогсоох, Шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэг 13 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.*

## Алдар цолтнуудад нэмэгдэл, хөнгөлөлт олгоно

Ахмад настны тухай болон алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн УИХ-д өргөн мэдүүлэхээр болжээ. Эдийн засаг хүндрэлтэй байгаа хэдий ч ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, мэдлэг, ур чадвараа өвлүүлэн үлдээх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нь нэмэгдүүлэх үүднээс хуулийн төслүүдийг боловсруулжээ. Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрт Ач санах хууль баталж, азай буурлуудаа "Насны хишиг" олгох эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан. Энэ дагуу 65 буюу түүнээс дээш насны ахмадуудаа жилд хоёр удаа 100-300 мянган төгрөг олгохоор ирэх оны төсвийн төсөлд тусгаад байгаа аж. Ахмад настны тухай хуулийн төсөл нь ахмад настны амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилготой бөгөөд дөрвөн бүлэг, 17 зүйлтэй. Ахмадуудад лавлагаа, мэдээллийн зөвлөгөө өгөх, сургах, хөгжүүлэх явуулын үйлчилгээ үзүүлэх, хэрэгцээтэй дэмжлэг, туслалцаа, үйлчилгээний талаарх мэдээллийг утсаар болон онлайн хэлбэрээр хүргэх зэрэг шинэлэг хэлбэрийн ажлыг хэрэгжүүлэхэд 750 сая төгрөг зарцуулахаар төлөвлөв.

## 319 иргэний хилийн хоригийг цуцалжээ

Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан зэргээр эрх ашгийг нь хохироосон асуудлыг шалгаж судлах Ажлын хэсэг Засгийн газрын ээлжит хуралдаанд санал дүгнэлтээ танилцуулжээ. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогтын ахласан тус Ажлын хэсэг дэргэдээ дэд ажлын хэсэг байгуулан ажилласан байна. Ажлын хэсэг хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдийг Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн талаарх судалгааг хийж, санал дүгнэлт гаргажээ. 2016 оны наймдугаар сарын 31-ний өдрийн байдлаар хил нэвтрэх эрхийг нь түдгэлзүүлсэн Монгол Улсын 5391, гадаадын 191, нийт 5582 иргэн бүртгэлтэй байсан байна. Харин ялын хугацаа дууссан, эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэсэн, шүүхийн шийдвэрийг биелүүлсэн зэрэг хуульд заасан үндэслэлээр Монгол Улсын 298 иргэн, гадаадын улсын 21 иргэн, нийт 319 иргэнийг Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлажээ. Үүнд прокурорын байгууллагын шийдвэрээр Монгол Улсын 164 иргэн, гадаад улсын 13 иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэрээр Монгол Улсын 128 иргэн, гадаад улсын хоёр иргэн, шүүхийн шийдвэрээр Монгол Улсын зургаан иргэн, гадаад улсын зургаан иргэн тус тус хамрагдсан байна.

Мөн тухайн хүнд өөрт нь мэдэгдэлгүйгээр төрийн албан хаагч дур зоргоороо авирлаж хилийн хориг тавьдаг, хориг тавьчихаад түүнийгээ таг мартдаг асуудлыг нэг мөр цэгцлэхээр шийдвэрлэжээ. Тухайлбал, Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гаргах, түүнийг цуцлах үйл ажиллагааг нэг цонхоор явуулах, хилээр гарахыг түдгэлзүүлсэн иргэдийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн сантай болох нь зүйтэй гэж үзэв. Түүнчлэн хилээр гарахыг түдгэлзүүлсэн шийдвэрийг ямар албан тушаалтан хэзээ гаргасан, хэзээ цуцлахыг тодорхой заах, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиудад холбогдох өөрчлөлт оруулах санал гаргасан байна.

## Хуулиас давсан заалттай 86 шийдвэрийг хүчингүй болгожээ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд одоо бүртгэлтэй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 971 захиргааны хэм хэмжээний актаас хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой Сайдын тушаал 168, Агентлагийн даргын тушаал 25, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж 44 нийт 237 шийдвэр байгаа аж. Уг 237 захиргааны хэм хэмжээний актыг Ажлын хэсгийн хүрээнд хянан үзээд холбогдох хуулиудад нийцээгүй 100 шийдвэр байсныг тогтоож, хууль зөрчсөн зөрчлийг арилгах үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яам 86 шийдвэрийг хүчингүй болгох, 14 шийдвэрийг шинэчлэн баталж бүртгүүлэх тухай дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ. Ажлын хэсэг мөн өнөөдөр байгаа 1400 гаруй нэр төрлийн тусгай зөвшөөрлийн тоог 2-3 дахин бууруулж, зөвшөөрснөөс бусдыг хориглох бус хориглосноос бусдыг зөвшөөрч,эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааг дэмжих санал гаргасныг Засгийн газар дэмжсэн байна.

> ...Тиймээс цаашид төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн өр төлбөрийг төр хариуцаад өнгөрөх биш тухайн гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг байх хууль журам боловсруулахаар тогтлоо...

## Төрийн албан хаагчийн хууль зөрчсөн буруутай үйлдлээс болж 15 тэрбум 319 сая төгрөгийн хохирол учирчээ

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохиролд 2013-2015 онд нийт 164 гүйцэтгэх баримт бичгийн 15.319.861.889 төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Үүнээс хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчид төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохиролд нийт 23 аж ахуйн нэгжид 25 гүйцэтгэх баримт бичгийн 11.843.753.084 төгрөг олгохоор шийдвэрлэжээ. Нөхөн төлбөр төлөх болсон шалтгааныг судлаж үзвэл, худалдан авагчаас шилжүүлсэн мөнгөнөөс их хэмжээний мөнгө завшсан Төрийн өмчийн хорооны ажилтнуудтай холбоотой, татварын өрөнд хуулийн этгээдээс хураасан орон сууцыг завшсан сумын Засаг даргатай холбоотой, шан харамж өгөөгүйгээс онцгой албан татвар Төлүүлэх тухай хууль бус шийдвэр гаргасан гаалийн байцаагчтай холбоотой төрийн албан хаагчдад холбогдох нэхэмжлэлд хохирол нөхөн төлөхөөр шүүхийн шийдвэр гарсан байжээ. Тиймээс цаашид төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн өр төлбөрийг төр хариуцаад өнгөрөх биш тухайн гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг байх хууль журам боловсруулахаар тогтлоо. Засгийн газрын хуралдаанаар Ажлын хэсгийн санал дүгнэлтэд тусгагдсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д тусгаж, хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт болон холбогдох сайд нарт даалгажээ. Мөн Засгийн газар, яам, агентлагийн төвшинд хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээг яам, агентлагийн төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтэд нь хяналт тавьж 2017 оны II дугаар улиралд Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд үүрэг болгожээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

МЭДЭЭЛЭЛ

# Н.ДАШДАВАА: "ЭРДЭНЭТ"-ИЙН 49 ХУВЬ МОНГОЛЫНХ БОЛСОН НЬ ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Одоо Чалкогоос үлдсэн 100 сая гаруй ам.долларыг 27 ам.доллараар бодож төлөхөд олон жил шаардлагатай болно. Үндэсний эрх ашиг эдийн засгийн хямралд санаа зовж байгаа улстөрчид байгаа бол одоо энэ гэрээнийхээ үнийг өсгөх тал дээр ажиллах хэрэгтэй. Онгөрсөн найман сарын хугацаанд л гэхэд энэ үнийн зөрүүнээс 2.1 тэрбум доллар олох боломжоо Монгол Улс алдлаа. Үүнийг эрх баригчид МУ-ын Засгийн газар яагаад нуугаад байгаа юм. Зөвхөн энэ алдагдал гэхэд "Эрдэнэт"-ийн 49 хувийг таван удаа худалдаж авах хэмжээний мөнгө" гэв. Харин маргаан мэтгэлцээний гол сэдэв болоод буй "Эрдэнэт"-ийн 49 хувийг худалдан авсан тухайд "Эрдэнэт Монголынх болсонд баяртай байна. Эрдэнэтэд хувийн хэвшлийн компани менежмент хийснээр эрх баригч намууд ээлжилж шахаа хийдэг хэрэгсэл биш болж байгаад баярлаж байгаа. Эрдэнэт үйлдвэрээс монгол хүнд хожил ирнэ. "Эрдэнэт"-д ард түмэн шахаа хийдэггүй. улстөрчид л шахаа хийдэг. Улстөрчид хувийн эрх ашгийн үүднээсхандаж байна. Эрдэнэтийг худалдан авсаныг шалгах хэрэгтэй. Улмаар түүнийгээ ард түмэнд нээлттэйгээр танилцуул. Ард түмнийг талцуулж, ард түмнийг сэтгэлгээний хямралд оруулмааргүй байна улстөрчид өө. Оросын ард түмний өмчид байсан 49 хувийг Монголд ирэхээр популизм хийж улстөрждөг тамын гурвалжингаасаа салах хэрэгтэй. МАН эрх барьж чадахгүй байна. АН, сөрөг хүчний үүргээ гүйцэтгэж чадахгүй байна. Эдгээр нөхдүүдийн "Эрдэнэт" болон төрийн өмчит компаниудад шахаа хийдэг улстөрчдийн тодорхой баримтуудыг гаргаж тавина. Монголчууд бид улстөрчдийн бүлэглэлийн тархи угаалтын тоглоомонд орж болохгүй" гэдгийг онцоллоо. Мөн Н.Дашдаваа "Тавантолгойн гэрээний нөхцөл, Эрдэнэтийн 49 хувь Монголынх болсон асуудал, Тавантолгойн төмөр замын 49 хувийг зарах асуудлуудаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл яаралтай хуралдаж, Үндэсний эрх ашигт нийцсэн шийдвэр гаргахыг уриаллаа.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

# Ц.Мөнх-Оргил: Зээлийг ганцхан БНХАУ биш ОХУ, БНСУ, Япон зэрэг түншийн харилцаатай орнуудаа санал тавьж байгаа

*УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргилоос зарим зүйлийг тодрууллаа.*

**-Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаад буй 18 тэрбум төгрөгийн өрийн асуудлыг тодруулаач. Та үнэхээр их хэмжээний өртэй юм уу?**

-Хөрөнгө орлогын мэдүүлэг АТГ-аас гарсантай холбогдуулж Ц.Мөнх-Оргил асар их хэмжээний өртэй гэсэн мэдээлэл цацагдсан байна. Үүн дээр тайлбар хийе. Надад тийм их хэмжээний өр байхгүй. УИХ-д нэр дэвшихэд ч байгаагүй, УИХ-ын гишүүн болоход ч байгаагүй, Засгийн газрын гишүүнээр сонгогдоход ч байгаагүй. Хэзээ байсан бэ гэвэл 2013 оноос 2016 оны тавдугаар сар хүртэл энэ өр байсан. Манай гэр бүлийн хүн 2013 оны дөрөвдүгээр сард "Гоёо" компанийг "Эм Си Эс Холдинг"-оос худалдаж авсан. Худалдаж авахдаа 25 хувийн төлбөрийг бэлнээр төлөөд, 75 хувийг нь зээлээр худалдаж авсан. Тэгэхээр Ц.Мөнх-Оргил "Эм Си Эс" юм уу өөр ямар нэгэн компаниас бэлнээр, шилжүүлгээр ямар нэгэн мөнгө аваагүй. Манай гэр бүлийн хүн хувьцаа зээлээр худалдаж авсан учраас санхүүгийн тайлангийн бичилт дээр тусгасан. Үүнийг хөрөнгө орлогын мэдүүлэг дээр тайлагнасан байгаа. Үүнээс хойш 2016 оны тавдугаар сард хувьцаа буцаан шилжүүлэх тухай гэрээ байгуулаад энэ хувьцааг нь буцааж өгсөн. Өр тэглэгдсэн. Одоо манай гэр бүлийн хүн "Гоёо" ХХК-ийн 25 хувийг эзэмшиж байгаа.



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

**-"Эм Си Эс" компанитай та ямар холбоотой юм бэ, таныг тус компанийн хүн гэж ярьдаг?**

-Миний хөрөнгө орлогын мэдүүлэг дээр олон жил бичээстэй яваа. Манай гэр бүлийн хүн "Эм Си Эс Холдинг" компанийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар дөрвөн жил ажилласан. Энэ хугацаандаа "Энержи Ресурс" компанийн ХонгКонгт гарсан IPO-г зохион байгуулсан. Ингээд гэрээнийхээ дагуу "Эм Си Эс Холдинг"-ийн 3.1 хувийн хувьцаа авсан. Тийм учраас манай гэр бүлийн хүн хувьцаа эзэмшигч, би өөрөө хувьцаа эзэмшигч биш. Би тус группийн ерөнхийлөгч Ж.Оджаргалтай арван жилийн найзууд. Бид 23 дугаар сургуульд хамт сурч, цэргийн алба хамт хааж, дараа нь Москвад олон улсын харилцааны дээд сургуульд хамт сурч байлаа. Гэхдээ бизнесийн харилцаа бол бизнесийнхээ харилцаагаар л явдаг.

**-Монгол Улсын гадаад өрийн асуудал хурцаар хөндөгдөж байна. Засгийн газар "Стэнд бай" хөтөлбөр авах эсвэл олон улсаас зээл авах гэсэн сонголттой байгаа. Эдийн засгийн хямралыг даван туулах хөтөлбөрийг хэзээнээс хэрхэн хэрэгжүүлэх гэж байгаа вэ?**

-Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хоёр удаа, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр нэг удаа хэлэлцсэн. Өнөөдөр дахиж хэлэлцээд, маргааш өглөө /өнөөдөр/ УИХ-ын даргад өргөн барина. Энэ хөтөлбөрт олон арга хэмжээ тусгасан байгаа. Хамгийн том тулгамдсан асуудал нь өр. 2017 оны тавдугаар сарын 30-нд бид хамгийн эхний төлбөр 580 сая ам.доллар төлнө. Үүнд бид зарчмын хоёр байр суурь баримталж байгаа. Нэгдүгээрт, ОУВС болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай тохирч Монгол Улсын өр, эдийн засгийн хямрал, өсөлтийг тусгасан хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж бодож байгаа. Гэхдээ хөтөлбөр хэрэгжүүлэх эсэх нь дан ганц манай Засгийн газраас шалтгаалах зүйл биш, нөгөө талаас бидэнд тавих санал, сонирхол, санал болгох хөтөлбөр зэргээс шалтгаална. Хэлэлцээр бол эхэлсэн. Энэ сарын 20-нд ОУВС-ийн төлөөлөгчид ирж, улсын дотоод нөхцөл байдал, юу хийх шаардлагатай зэргээр мэдээлэл цуглуулж байна. Засгийн газар, Монголбанк, Сангийн яамныхан уулзаж мэдээ баримтуудаа тулгаж байгаа. Дараа нь хэлэлцээ эхэлнэ. Бусад орноос хөнгөлөлттэй зээл авах эсэх асуудлыг мэдээж судалж үзэхээс аргагүй. Ганцхан БНХАУ биш ОХУ, БНСУ, Япон зэрэг түншийн харилцаатай орнуудаа санал тавьж байна. Гэхдээ ОУВС болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажиллах ажлын хүрээнд үүнийг зохицуулна.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин эдүгээ сүүлээ хавчуулсан чоно шиг шил даван одоцгоосон. Гэхдээ нам хүнээр, гишүүнээр дутдаггүй аж. Чамтай чамгүй үүр цайна гэдэг шиг. Орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгуульд халзан нөхөр намаа аваад орсон. Үнэндээ түүнээс өөр хүн ч байгаагүй. Бууриа сахиж үлдсэн хэд нь нуруугаа авахуулсан морьд шиг зуларч гүйлдээд л. Харин тэр чадсан. Үнэмлэхүй эрх мэдэл бүхий намтай тулж, нийслэлийн гурван дүүрэг, 150 гаруй суманд ялалт байгуулсан

...Иймээс Ардчилсан нам үлдэж буй хугацаанд маш болгоомжтой хөдлөх ёстой. Тэгж чадахгүй урьдын адил дотроо “алалцаад” байх аваас энэ нам улс төрийн тавцангаас МАХН-ын нэгэн адил сураггүй болтлоо арчигдахад хүрнэ. АН-ын их хурал болоход тун бага хугацаа үлдээд байгаа. Дээр нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль хаянд ирсэн байгааг сануулахад илүүдэхгүй биз ээ...

# БЯЛДУУЧИД НЬ ШИЛ, АМИА ХИЧЭЭГСЭД НЬ ХИЛ, ЛИДЕРҮҮД НЬ ФРАКЦИ ДАВСАН АН

нь том амжилт, өнөөгийн нөхцөл байдалд. Түүний халаасанд эрх мэдэл, тараах мөнгөний аль аль нь байгаагүй. Албан тушаал нь хүртэл Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Эрдэнэбат өмнө нь ч ялагдал хүлээж, гудамжаар нэг тарсан гишүүд бүхий намын генсекээр дөрвөн жил ажиллахдаа намын ерөнхий нарийн бичгийн дарга хүн ямар байдлаар ажиллах ёстойг харуулж, стандарт хэм хэмжээг нь тогтоож чадсан төдийгүй 2012 оны УИХ-ын ээлжит сонгуульд Ардчилсан нам үнэмлэхүй ялалт байгуулж байлаа. Харин эдүгээ АН нам биш болж байх шиг байна. Сонгуульд ялагдсаныхаа дараахан шинэчлэгдэх тухай яриад таг болов. Цаг хугацаа өнгөрөх тусам хойргошиж, хэдхэн хүний асуудал болж байх шиг байна. Бидэнд чадахгүй бол нэрийг нь өөрчлөөд ч болов хуулах хичээл бэлхэнээ хажууд буй. МАН 2012 оны сонгуулийн дараа УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааныг хоёрдугаарт тавьж байгаад л намын дарга, Ерөнхий нарийн бичгийн даргаа сольж байлаа. Орон нутгийн сонгуулийн дүн муугаар эргэхэд ч ялгаагүй хэдэн өдөр хуралдаж, наана цаанаа гарч байгаад л дарга нараа сольсон. Ардчилагчдад харин ийм зүрх зориг алга. Байсхийгээд л ҮЗХ-ны хуралдааны тов зарлагддаг ч тэр нь хуралдаж байсангүй. Тэгээд ч Ардчилсан намд “Шонхор”, “МҮДН”, “Нэг Ардчилал”, “Алтангадас” зэрэг олон фракци бий. Өнгөрсөн дөрвөн жилд “Шонхор”-ынхон даам гарч, албан тушаалын томилгоонуудын өнгөтэй өөдтэйг нь хамж байсан ч УИХ-ын сонгуульд намаа тавьж туусан.

Тиймээс МҮДН тэрүүхэн хүрээндээ тэднийг буулгаж аваад байгаа. Гэвч З.Энхболдыг барж идэж чадахгүй байгаа нь үнэн. Орон нутгийн сонгууль өндөрлөмөгц мань эр Ерөнхийлөгчийн сонгууль хүртэл Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллая хэмээгээд үүнийхээ шан болгож, МҮДН цаашлаад Д.Эрдэнэбатыг намын даргад өрсөлдөхөд нь хүч хавсаръя гэх тохироог хийсэн ч байж мэднэ. Гэхдээ тэр байр суурьгүй нэгэн эцсийн мөчид хаашаа ч хувирч магадгүй нөхөр. Нөгөөтэйгүүр, “Шонхор”-ынхон С.Эрдэнээ хэрхэн аргалах тодорхойгүй. “Би намын дарга болно оо” гээд зүтгэчихвэл буулгаж авахад хэцүү дээ хэцүү. Тэдний нөгөө талд “Нэг Ардчилал” буюу Л.Гантөмөр, Х.Тэмүүжин нарын залуус “Бид намын удирдлагаа гартаа авч, намаа шинэчилнэ” хэмээн ил цагаан байр сууриа илэрхийлэх болсон. Тэднийг Ц.Элбэгдорж, Э.Бат-Үүл хоёр дасгалжуулж байгаа гэх яриа бий.

Хэн хэнд нь тэднийг өдөөх сонирхол буй. Э.Бат-Үүлд 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх сонирхол байгаа бол тэр үед Ерөнхийлөгчийн сэнтийгээ тавьж өгөх Ц.Элбэгдоржид дахин намын дарга болох мөрөөдөл буй. “МҮДН” болон “Нэг Ардчилал”-ынхан ийнхүү хоорондоо нааш цааш болж байх зуур Ардчилсан намд нэгэн цаг үед хүчтэй явсан “Алтангадас”-ынхан ч зүгээр суухгүй биз. Аягүй бол Я.Санжмятавыгаа зүтгүүлж мэднэ. Тус фракцийн лидерүүд болох Л.Болд, С.Баярцогт, Р.Гончигдорж нар МоАХ руу “урваж”, С.Баярцогт нь АНУ-д докторын зэрэг хамгаалах нэрээр мөрөө хөөж одсон. Иймээс Ардчилсан нам үлдэж буй хугацаанд маш болгоомжтой хөдлөх ёстой. Тэгж чадахгүй урьдын адил дотроо “алалцаад” байх аваас энэ нам улс төрийн тавцангаас МАХН-ын нэгэн адил сураггүй болтлоо арчигдахад хүрнэ. АН-ын их хурал болоход тун бага хугацаа үлдээд байгаа. Дээр нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль хаянд ирсэн байгааг сануулахад илүүдэхгүй биз ээ.

Дугаарын 60 мөр

## Сонгуулийн хуулиа чангалаад юу өөрчлөгдөв

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Саяхан орон нутгийн сонгууль болж өндөрлөлөө. Нийслэлийн хэмжээнд сонгогчдын ирц хангалтгүй байлаа. Залуучуудын итгэл алдарч, аль ч намыг сонгосон хоосон амлалт, хий улстөржилт, өөрсдөө баяжихаас өөрийг хийхгүй юм чинь саналаа өгөхгүй гэдэг үүднээс хандав бололтой. Гэтэл хоёр том нам улаан цагаан мөнгө тараах ажил хийлээ. Ерөөсөө ил цагаандаа гарсан. Тухайлбал, дахин санал хураалт явуулсан хэсгүүд дээр ажиллаж байгаа хүмүүс иргэд рүү утасдаж, “Саналаа ирж өг, 20, 30 мянган төгрөг өгье. Тэр хүний төлөө дугуйлчихаарай” гэсэн байгаа юм. Энэ бол зүгээр л хэвийн зүйл болж хувирсан. Сонгууль биш, хар захын наймаачид юм уу, хаашаа юм. Ингэж санал өгүүлнэ ч гэж байхгүй байх аа. Түүнээс гадна сонгуулийн санал авах хэсэг дээр ажиллаж байсан зарим хүмүүс иргэдийн саналаа өгснийг батлах цагаан хуудсыг хурааж авсан тохиолдол нэлээд гарсан. Бүр зарим нь нэг хуудсыг 5000 төгрөгөөр худалдаж авсан. Цагаан хуудсаа зарсан олон хүн энэ талаар ярьж байна. Бодвол “Таны төлөө ийм хүмүүсээр санал өгүүллээ” гэж цааш нь аль нэг нэр дэвшигчид өгөөд, мөнгө авч байгаа юм байлгүй. Сонгууль ийм л бохир заваан, балиар болж байна. Өнөөх мөнгө тараах асуудал бол бүр цайрсан. Залуучууд ч гэсэн жаахан оройхон мөнгө өгөхөөр нь саналаа өгнө гээд сууж байх жишээтэй. Өнөөх хатуу чанга сонгуулийн хууль чинь яав аа. Үйлчилсэнгүй, эрх мэдэлтэн, эвэртэн тууртнуудаа. Ийм хэрэгжихгүй хуулиар яадаг юм. Мөнгө тараах, сонгогчдын саналыг худалдаж авах гаж тогтолцоог өөрчлөх гэж л хатууруулсан биз дээ. Гэтэл гол зорилгодоо хүрсэнгүй. Ингэж сонгууль зохион байгуулаад ч яах юм. Одоо бүр иргэд нь амташчихсан, “мөнгө өгөхөөр нь сонгуулиа өгнө” гээд гүрийгээд суучихдаг боллоо. 2020 оны УИХ-ын сонгуулиар ийм зүйл тохиолдвол яах вэ. Залуучуудын ихэнх нь саналаа өгөхгүй гүрийгээд, тэдэн төгрөг өгвөл л хуудсыг чинь бөглөж, хэн нэгэн улстөрчийг сонгоно гээд суучихвал яах юм. Ирц хүрэхээ болиод, дахин санал хураалт явуулж, дээрээс нь мөнгө төлж байж иргэдийн саналыг худалдаж авдаг жишиг тогтвол яах вэ. Ийм гаж жишиг тогтоохгүй гэж л уг нь сонгуулийн хуулиа чангалж, мөнгө тараах асуудалтай тэмцэхээр болсон юм биш үү. Эсвэл хэвлэлүүдийг чангалж, залуусыг боомилох гэсэн л зорилготой байсан юм уу. Аль аль санаа чинь бүтсэнгүй “нохдууд” минь. Дараагийн сонгуулиар энэ мэт асуудлаа бодолцоно биз, одоогийн эрх баригчид.



УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

# Н.УЧРАЛ: МОНГОЛЧУУДАД ОЮУНЫ ЭКСПОРТ ХИЙХ БОЛОМЖ БАЙНА

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Эдийн засгийн нөхцөл байдал ийм амаргүй байгаа үед бид төсвийнзахилгабатыгсахихёстой. Гэтэл зарим яам, агентлагууд дээр төсөв нь өсчихсөн байгаа. Мэдээж байгууллага болгон өөр өөрийн шалтгаанаар нэмэгдсэн байж болно. Гэхдээ ямар ч байсан бид төсвийн сахилга батыг баримтлахын тулд норм, нормативыг баримтлах шаардлагатай.

**-Тэвчиж болох зардлуудын тухай их ярьж байна. Та үүн дээр ямар байр суурьтай байгаа вэ?**

-Төсвийн тэнцлийг алдагдуулахгүй хэмнэлтийг хийж, шаардлагатай зүйл рүүгээ гүйлгэж болох олон асуудал байгаа. Тухайлбал, таван сая төгрөгөөс дээш сургалтын төлбөр авдаг ерөнхий боловсролын сургуулиуд манайд байдаг. Гэтэл эдгээр сургуулиуд яагаад улсаас хувьсах зардал аваад байгааг ойлгохгүй байгаа. Хувьсах зардлын 60 хувийг олгоно гэсэн Засгийн газрын тогтоол байдаг. Гэхдээ манай улсад таван сая төгрөгөөс дээш сургалтын төлбөр авдаг найман дунд сургууль бий. Эдгээр сургуулиудад суралцаж байгаа хүүхдүүдэд олгох хувьсах зардалд 1.2 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа юм. 1.2 тэрбум төгрөг гэдэг чинь их мөнгө биз дээ. Гэтэл нөгөө сургуулиуд таван сая төгрөгийн төлбөр аваад, орлого олоод, үйл ажиллагаагаа хангалттай явуулчихдаг хэрнээ улсаас хувьсах зардал аваад байна. Энэ бол илүү зардал гэж харж байна. Тиймээс би Засгийн газарт албан ёсоор хүсэлтээ хүргүүлнэ. Орлоготой сургуульд өгөх хувьсах зардлын 1.2 тэрбум төрөгийг багасгаад, өөр шаардлагатай зүйлд хөрөнгө оруулалт хийгээч гэдэг хүсэлтээ өгнө. Мөн төрийн өмчийн их, дээд сургуулийн асуудал байна. Өнөөдөр төрийн өмчийн их, дээд сургуулиуд сургалтын төлбөр авдаг. Түүгээрээ үйл ажиллагаагаа санхүүжүүлээд явдаг. Тэгсэн хэрнээ 2017 оны төсвийн төсөлд тогтмол зардалд зориулан 6.7 тэрбум туссан байна. Яах вэ, Боловсролын тухай хуулиар төрийн өмчийн бүх шатны сургуулиудын тогтмол зардлыг улсаас санхүүжүүлнэ гээд заачихсан байдаг. Гэхдээ энэ хуульд зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулж, 6.7 тэрбум төгрөгийг авах шаардлагатай. Учир нь бусад сургуулиуд өөрийнхөө төлбөрөөр санхүүжиж болоод байхад, яагаад төрийн сургуулиуд тогтмол зардлаа улсаас аваад төсөвт ачаалал үүсгээд байгаа юм бэ. Үүнийг болих ёстой гэдэг байр суурьтай байна. Энэ мэтээр үр ашиггүй зарцуулалтуудыг хасч, төсвийн хэмнэлтийг хийх хэрэгтэй байна. Энэ удаагийн төсвийн зарлагыг нэмэгдүүлж огт болохгүй. Тиймээс төсвийн тэнцлийг алдагдуулахгүй нэгээс нөгөөд шилжүүлэх боломж бий. Ер нь энэ Засгийн газрын хийсэн нэг том дэвшилтэт ажил бол төсөв дөрвөн урсгалаар гарч байсныг нэг болгож чадсан явдал. Одоо Монгол Улсын төсөв нэг урсгалаар гардаг нэг төсөвтэй болсон.

**-МАН-ын мөрийн хөтөлбөрийн нэг гол зүйл нь гурван ээлжээр хичээллэдэг сургуулиудын асуудлыг шийдвэрлэж, хүрэлцээг сайжруулахаар тусгаж өгсөн байсан. Гэтэл энэ удаагийн төсөвт сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт тусгагдаагүй байсан?**

-Төсөвт нэмэлт хөрөнгө оруулалт тусаагүй. Гэхдээ концессоор нэлээд олон сургууль, цэцэрлэгийн асуудал шийднэ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлийн болон улсын хэмжээнд гурван ээлжээр хичээллэдэг сургуулийг бүгдийг нь хоёр ээлжтэй болгоно гэдгийг тусгаад өгчихсөн. Тиймээс цаашдаа гурван ээлжтэй сургууль байхгүй болно гэсэн үг. Тухайлбал, миний сонгогдсон Сонгинохайрхан дүүрэгт л гэхэд гурван ээлжээр хичээллэж байгаа арван сургууль байна. Тэгвэл бид хоёр жилийн дотор эдгээр сургуулийг хоёр ээлжтэй болгоно. Тиймээс шинэ сургууль, цэцэрлэгүүдийг барина. Засгийн газрын хурлаар нэлээд олон сургууль, цэцэрлэгийг концессоор барихаар жагсаалт батлагдчихсан байгаа. Манай дүүрэгт гурав, бүр дөрвөн ээлжээр хичээллэж байгаа ч сургууль бий. Тухайлбал, 62 дугаар сургууль дөрвөн ээлжээр хичээллэж байгаа юм билээ. Учир нь Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороонд сургууль, цэцэрлэг огт байхгүй. Тиймээс энэ хорооны хүүхдүүд 62 дугаар сургуульд суралцаад ачааллыг нь өсгөчихдөг юм. Тэгэхээр тус сургуулийн 450 хүүхэд суралцах боломжтой өргөтгөлийн байрыг энэ жил концессоор барина. Уг нь Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороонд концессоор сургууль, цэцэрлэгийн цогцолбор барихаар шийдвэрлэгдсэн юм билээ. Гэхдээ асуудал нь шүүх дээр маргаантай байгаа гэсэн. Тиймээс би энэ асуудлын зангилааг нь тайлж, тус хороонд цогцолборын байрыг барихаар ажиллаж байна. Мөн Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороонд 120 ортой хүүхдийн цэцэрлэг барих асуудлыг судалж үзээд, концесст оруулахаар ажиллаж байна. Ганцхан газрын асуудал нь шийдэгдээгүй. Тиймээс газар чөлөөлөлтийнасуудлыгдүүрэгтэй ярьж байгаад шийднэ. Энэ мэт асуудал шийдэгдчихвэл сургууль, цэцэрлэгийнхүрэлцээболомжийн болно гэж харж байгаа. Үүнээс гадна Монгол Улсын цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нийт хүүхдүүдийн 60 хувь нь манай дүүрэгт байдаг. Тэгвэл дүүргийн асуудлыг шийдчихвэл улсын хэмжээний асуудал шийдэгдэнэ гэж хэлж болно. Ер нь хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаагаас ээжүүд хүүхдүүдээ хараад, ажилгүй болдог. Тиймээс тухайн өрхийн орлого буурдаг. Монгол Улс түүхэндээ 2016 онд өрхийн орлого хоёр дахь удаагаа буурсан. Үүнд хамгийн том нөлөөлж байгаа зүйл нь цэцэрлэгийн асуудал болдог. Тиймээс ч энэ мэт асуудлыг яаралтай шийдэхээр ажиллаж байна.

**-Монгол Улсын цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нийт хүүхдүүдийн 60 хувь гэхээр нэлээд том тоо байна. Уг нь сургууль цэцэрлэг баригдтал эцэг, эхчүүд хүүхдээ “Хүүхэд харах үйлчилгээ”-нд хамруулж эхэлсэн. Гэтэл энэхүү үйлчилгээг он гараад зогсооно гээд байна. Энэ тал дээр ямар байр суурьтай байна вэ?**

-Хүүхэд харах үйлчилгээний хувьд дутагдалтай зүйл олон бий. Тухайлбал, байрны стандартыг нь тавьж өгөөгүйгээс болоод “Хүүхэд харах үйлчилгээ” нэрийн дор шаардлага хангахгүй хүйтэн, эрүүл ахуйн стандарт хангахгүй бохир орчинд хүүхэд харах үйлчилгээ явагдаад байсан. Тиймээс үүнийг “Цалинтай ээж” хөтөлбөрболгонүргэлжлүүлэхээр болж байгаа. Өөрөөр хэлбэл, ээжүүд гэртээ урамшуулал аваад, хүүхдээ харах болж байна. Хүүхэд харах үйлчилгээ хэлбэр нь өөрчлөгдөөд ээжүүд өөрсдөө хүүхдээ хардаг болж байгаа гэсэн үг. Түүнээс хүүхэд харах үйлчилгээ бүрэн цуцлагдаад, бид эхчүүдийг ажилгүй, орлогогүй орхиод байгаа зүйл огт биш. Засгийн газрын хөтөлбөрт “Цалинтай ээж” хөтөлбөр суучихсан. Одоогийн байдлаар хэлэлцэгдээд явж байна. Тиймээс тун удахгүй хэрэгжээд эхэлнэ.

> ...“Цалинтай ээж”, “Насны хишиг”, “Боловсролын зээлийн сан”, аж ахуйн нэгжүүдийн татварыг багасгах асуудал гээд олон зүйлийг хэрэгжүүлээд эхэлчихлээ. Гуравхан сарын хугацаа гэхэд Засгийн газар мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлээд эхэлнэ гэдэг бол маш том давуу тал юм...

**-Эдийн засгийг сэргээхийн тулд эрх баригчид янз бүрээр л ажиллаж байх шиг байна. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нар АНУ-д айлчилж, олон улсын “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах эсэх асуудлыг хөндсөн. Энэ гарц мөн үү?**

-Одоо 6.6 их наяд төгрөгийг бид зээлийн үйлчилгээний төлбөрт төлөх гэж байна. Энэ нь манай улсын төсвийн орлогыг давчихсан үзүүлэлт. Тэгэхээр ийм нөхцөл байдлыг шийднэ гэдэг бол бэрхшээлтэй л байна. Тиймээс ч Засгийн газар бүх л боломжит хувилбарыг судалж байгаа. Түүний нэг нь “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах эсэх асуудал юм. “Стэнд бай” хөтөлбөрийн хувьд шалгуур их өндөр. Шалгуур өндөр байх тусам халамжийн бодлогоо аль болох цуцлах шаардлага тулгарна. Төсвийн сахилга бат хэт өндөр болж эхэлнэ. Энэ ч утгаараа ард иргэдийн нуруун дээр хэт их ачаалал ирэх магадлал байгаа. Гэхдээ давуу тал бас бий. Тухайлбал, төсвийн сахилга баттай болно. Хариуцлагатай болж төсөв хэмнэгдэнэ, бага хүүтэй зээл олгох учир эдийн засаг богино хугацаанд сэргэчих боломжтой. Өмнө нь “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдаад манай улс эдийн засгийн өсөлтийг хурдан хугацаанд хийж чадаж байсан. Цаанаас нь боломжийн шалгуур тавьчихвал “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдахад буруудах зүйл байхгүй. Харин шаардлага хэт өндөр байвал цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэхгүй байгаа энэ цаг үед ард иргэд хэрхэн амьдрах билээ гэдэг асуудал яригдах болно. Тиймээс Засгийн газрын зүгээс шаардлагаа уян хатан тавих юм бол “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах ёстой гэдэг байр суурьтай байгаа. Өөр нэг арга нь өөрсдөө бонд босгох боломж байна. Энэ бол бас нэг хувилбар юм. Өөрөөр хэлбэл, бондын мөнгийг бондоор нь төлөх асуудал. Тэгэхгүй бол төсвийн орлогоор зээлийн үйлчилгээний төлбөрийг төлнө гэж байхгүй. Тиймээс бондыг бондоор нь төлж байж, төсвийн орлогоо зөв зүйлд зарцуулах болно. Одоохондоо өөр арга зам байхгүй байна. Харин Монгол Улс төвийг захисан бодлоготой байх ёстой. Тиймээс нэг улс хэт их хэмжээний зээл, тусламж авах нь зохимжгүй.

**-Засгийн газрын 100 хоног болох гэж байна. Энэ хугацаанд Засгийн газрыг хэр ажилласан гэж харж байгаа вэ?**

-Ард түмэн МАН-д яагаад итгэл хүлээлгэсэн бэ гэхээр намын мөрийн хөтөлбөрт итгэсэн. Тэгвэл намын мөрийн хөтөлбөрийн 97-98 хувь нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдаж чадсан. Тиймээс УИХ-ын гишүүд хэрэгжилтэд хяналт тавиад явах хэрэгтэй. Засгийн газар өнгөрсөн хугацаанд мөрийн хөтөлбөрүүдээ хэрэгжүүлээд эхэлсэн. Тухайлбал, “Цалинтай ээж”, “Насны хишиг”, “Боловсролын зээлийн сан”, аж ахуйн нэгжүүдийн татварыг багасгах асуудал гээд олон зүйлийгхэрэгжүүлээдэхэлчихлээ. Гуравхан сарын хугацаа гэхэд Засгийн газар мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлээд эхэлнэ гэдэг бол маш том давуу тал юм.

**-Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор дөрвөн салбарт ААНОАТ-ыг нэг хувь болгох хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Дөрвөн салбарыг онцлоод байгаа нь хэр зөв шийдвэр юм бэ?**

-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор дөрвөн салбарт ААНОАТ-ыг нэг хувь болгох хуулийг оруулж ирснээрээ ажлын байрыг нэмэгдүүлнэ гэж үзээд байгаа. Гэтэл ажлын байр яг хэдээр нэмэгдэх вэ гэдэг тооцоолол алга. Хоёр дахин нэмэгдэнэ гэж яриад байгаа ч нэг аюултай зүйл нь компаниуд жижиг болох асуудал хөндөгдөж байгаа. Барилгын материалын үйлдвэрлэлийг би хувьдаа дэмжихгүй байгаа. Учир нь Монгол Улсад арай гэж өсч байсан томоохон үйлдвэрүүд 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой болохын тулд компаниудаа жижиглэх магадлалтай. Тэгээд ч үйлдвэрүүд жижигрэх тусмаа чанаргүй болдог шүү дээ. Түүнчлэн газар тариалангийн хувьд улсаас маш их хэмжээний тусламж авдаг салбар. Тиймээс хөнгөлөлт эдлэж байгаа бол урамшуулал авдаггүй байх хэрэгтэй. Түүнээс хөнгөлөлт ч эдлээд, урамшуулал ч авдаг байж болохгүй. Эдгээр салбарын оронд оюуны экспорт хийж байгаа салбаруудыг дэмжих хэрэгтэй. Шинэбүтээгдэхүүнболонашигтай загвар гаргаж байгаа мэдээлэл технологийн салбарыг дэмжиж чадвал монголчууд оюуны экспортыг хийж чадна. Тиймээс мэдээлэл технологийн салбарыг ААНОАТ-ыг хөнгөлөлтөд оруулах хэрэгтэй.

**-Орон нутгийн сонгуулийн өмнө сонгогчидтойгоо явж уулзсан байх. Иргэд “Насны хишиг” хөтөлбөрийн талаар ямар байр суурьтай байна вэ?**

-“Насны хишиг” хөтөлбөрийг сая бид бүлэг дээр ярьсан. Энэхүү хөтөлбөрийн насыг наашлуулж 65 болгохоор яригдаж байна. Тиймээс насыг наашлуулахын зэрэгцээ ахмадуудыг ялгаварлаж, 300, 600 мянган төгрөг гэхгүйгээр нэг түвшинд барих санал гаргаад байна. Би Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүний хувьд гишүүдтэйгээ нийлээд зарчмын зөрүүтэй санал гаргаад, дэмжигдээд байгаа. Цаашдаа бусад гишүүд ч дэмжих байх гэж найдаж байна. Тиймээс 65-аас дээш настай ахмадуудад жилд хоёр удаа 100 мянган төгрөг өгч байхаар яригдаж байна. Насыг 65 гэж тогтоох гээд байгаагийн учир нь төрийн албанд ажиллах дээд нас 65 байдаг. Тиймээс 65 наснаас эхлээд ахмадуудад цагаан сараар, наадмаар хоёр удаа 100 мянган төгрөг өгчихвөл ахмадуудад нэлээд нэмэр болоод явна. Гэхдээ нэг зүйлийг ялгаж, салгаж ойлгох хэрэгтэй. “Насны хишиг” бол тэтгэвэр биш. Харин ахмадуудын тэтгэмж юм гэдгийг ойлгох хэрэгтэй. Төсөв дээр жаахан ачаалал үүсэх байх. Гэхдээ төсвийн тэнцлээ алдагдахгүйгээр дотор нь гүйлгээд шийдэж болно гэж харж байгаа. Тойргийн сонгогчидтойгоо уулзаад явж байхад “Насны хишиг” хөтөлбөрийн насыг 65 болгож өгөөч гэдэг саналыг хамгийн их тавьж байсан. Тиймээс ч ажил хэрэг болгохоор ажиллаж байна. Байнгын хороон дээр уг асуудал дэмжигдсэн.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

18 дахь жилдээ МОНГОЛЫН МЭДЭЭ
Улиралд 44 дугаар
Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна
захиалгын үнэ 15400

# ОНЦЛОХ ХУУДАС

Õýí íü õýí áý?



# ДҮНСГЭР ГЭГДДЭГ Ч ШУУРХАЙ ДЭЭРЭЭ ШУЛУУХАН АВДАГ П.ГАНХҮҮ

Ч.ЧУЛУУН

“Хэн нь хэн бэ” булангийнхаа энэ удаагийн дугаарт Эрчим хүчний сайд П.Ганхүүг онцолж байна.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

“Салбарын сайд болсноор хариуцлага өөрчлөгдөх юм уу” гэж асуусан сэтгүүлчийн асуултад тэрбээр “Бодлого боловсруулж, шийдвэр гаргахын хувьд мэдээж өөрчлөлт гарна. Харин бидний ажил секунд, минутаар салбарын ажлын үр дүн хэмжигддэг хариуцлагатай алба гэдэг үүднээс нь ойлговол өөрчлөлт гарсан гэж бодохгүй байна. Хүмүүс гэртээ орж тогоо асаахад л цахилгаан цэлсхийж, хоол ундаа идэж уух тухтай нөхцөл бүрдүүлдэг мэргэжилтнүүд манайд ажилладаг. Би тэдний л нэг нь. Мэргэжилтнээс нь эхлээд зүтгэж яваа болохоор энэ том айлын галыг алдуулахгүй залгаж, хөгжүүлэх мөрөөдөл минь хэвээрээ гэж хэлж болно. Манай салбарт ердөө 3-5 том үйлдвэр байгуулах нь зүйтэй гэсэн бодлогыг бид барьж байгаа. Иймээс Дулааны III цахилгаан станц, Дорнодын цахилгаан станцын өргөтгөл болон Тавантолгойн цахилгаан станц зэрэгт бид өндөр ач холбогдол өгч байна. Цаашид экспортын чиглэлийн томоохон эх үүсвэр, дамжуулах шугам сүлжээ барьж байгуулахад анхаарал хандуулж ажиллана” хэмээн хариулсан эрхэм бол Эрчим хүчний сайд П.Ганхүү. Тэр бол олон нийт хийгээд гүйцэтгэх засаглалд харьцангүй шинэ хүн. Эдүгээ улстөрч болохоор гарааны шугамд зогсч буй тамирчин. Шулуухан хэлэхэд, аз, хийморь хоёрынхоо буянаар улс төрд хар гүйхээрээ гарч ирсэн сайд. Эрчим хүчний сайдад нэр дэвшигчдийг тодруулах үед түүний нэр сураг ч үгүй байсан. Гэхдээ мэргэжлийн гэх тодотгол бүхий Засгийн газрыг авч яваа цөөн хүний нэг гэж хэлж болно. Түүний намтар нь ч гял цял юмгүй, энгийн. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын уугуул. Пүрэвжав хэмээх гурван хүүхэдтэй багш эрхмийн дунд хүү юм билээ. Хөдөөгийн хүн ам цөөн, буйдхан сумын багачуудын нэгэн адил өвөлд нь голынхоо мөсөн дээр наадаж, зундаа хөх болтлоо усанд шумбаж өссөн нэгэн. Сурлагаар аймаг, сумандаа гайхагдсан сурагч байгаагүй ч хувиа борлуулж, довоо шарлуулж явсан хүү байсан талаар түүнийг Эрчим хүчний сайд болсных нь дараа сонсогдож л байв. П.Ганхүүг зарим нь дуу муутай дүнсгэрдүү хүн хэмээх нь бий. Төрөлхийн араншин нь юм хойно яалтай билээ. Гэхдээ тэр дуугарах үедээ хэнээс ч илүү тод дуугарч, байр сууриа илэрхийлж чаддагийг нь эрчим хүчнийхэн мэднэ. Сумандаа арван жилийн сургуулиа, улмаар Нийгэм, эдийн засгийн дээд сургуулийг 1997 онд, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг 1999 онд, Австралийн Сиднейн их сургуулийг 2015 онд тус тус дүүргэжээ. Эдийн засгийн магистр зэрэгтэй, АНУ, Япон Улсад эрчим хүчний чиглэлээр мэргэшил дээшлүүлсэн тэрбээр 1997-1999 онд Нийгэм, эдийн засгийн дээд сургуульд багш, салбарын эрхлэгч, 1999-2001 онд МУИС-д “ТАСИС” төслийн зөвлөх, 2002-2004 онд Дэд бүтцийн яаманд мэргэжилтэн, 2004-2009 онд Түлш, эрчим хүчний яаманд газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, 2009-2012 онд Эрчим хүчний газрын орлогч даргаар ажиллаж байсан гэдгээс өөр зүйл алга. Харин энэ цаг үеэс хойш насан туршдаа Эрчим хүчний сайдаар ажиллаж байсан гэх чимэг үгээр мөнхөд гангарна. Үр сад ч нь ялгаагүй. Харин түүнийг, тодруулбал, Нийгэм эдийн засгийн дээд сургуульд багш, салбарын эрхлэгчээр ажиллаж явсан залууг улс төрд, бүр Дэд бүтцийн яаманд мэргэжилтнээр томилон өөд татсан эрхмийнх нь талаар хэвлэлийнхэн одоохондоо дуугараагүй л байна. Хурдан удмын хэдэн сайхан адуутайг нь, хурды моринд “нугасгүй”-г нь мэдэх зарим нь М.Энхболдын хүн гэлцэх л юм билээ. Ирэх зуны наадмаар сайдын нэр дээр уясан хурдан хүлгүүд нь улсад түрүүлэх нь дамжиггүй. Тэгээд ч улс төр хэмээх халуун тогоонд буцалсан хүн “Сайдаар ажилласан, одоо улс төрөөс хөндийрөх цаг болсон” гээд чимээгүйхэн оддоггүй нь туйлын үнэн тул нэгэн цагт түүний улс төр дэх загалмайлсан эцгийн нэр тодрох нь гарцаагүй. Нөгөөтэйгүүр, түүнийг салбарынхан нь “Энэ салбарыг эдийн засгийн ухаанаар удирдах цаг болсон” хэмээн ихэд талархан хүлээж авсан гэнэ билээ. Ямартай ч тэрбээр ажлаа хүлээж авсан даруйдаа яамны шуурхайг хэд хэдэн удаа ширүүхэн хуралдуулж, салбарынхандаа ямар зарчмаар ажиллах талаараа “Энэ салбарт мэргэжлийн, мэргэшсэн боловсон хүчин ажиллах ёстой. Алдаа дутагдал гаргах эрхгүй салбар. Алдаа гаргасан хэн нэгнийг өрөвдөж, хаацайлах ёсгүй” гэсэн хэдхэн үгээр ойлгуулж чадсан байдаг. П.Ганхүүг намчирхдаггүй, халаа сэлгээ хийгээгүй сайд гээд хэлчихвэл худлаа болно. Тэрбээр өнгөрсөн есдүгээр сарын дундуур халаа сэлгээ хийж эхэлсэн. Гэхдээ яг өөрийнхөөрөө шийдсэн үү гэвэл бас эргэлзээтэй. Сайдын халаа сэлгээ Дулааны цахилгаан станцуудын дарга нараа солихоос эхэлж, Эрчим хүчний хөгжлийн төв, Диспетчерийн үндэсний төв гэхчилэн үргэлжилсэн байх жишээтэй. Түүний хийсэн томилгоо зарим газар, хэлтэст нүдээ олсон бол мэргэжлийн гэхээсээ илүүтэй менежмент шаарддаг агентлагуудад нь намын нөлөө орсон нь илт байгаа. Эрчим хүч өөрөө хатуу сахилга бат, мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг салбар болохоор үе үеийн сайд нар халаа сэлгээг хийхдээ салбар дотроо эргэлддэг зарчмаас П.Ганхүү ч гажаагүй л байна лээ. Үнэндээ түүнд ДЦС-III ТӨХК-ийн дарга асан Д.Чимэддорж шиг мэдлэг нь гарт нь багтсан чадалтай инженерийг дэргэдээ авах шиг оновчтой шийдэл хаа байх билээ.

Тэрбээр эдүгээ эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг. Эхнэр нь одоогоор бага хүүхдээ хараад гэртээ сууж байгаа аж. Эрчим хүчний сайд АТГ-т гаргаж өгсөн хөрөнгө орлогын мэдүүлэгтээ орон сууц 2, хувьдаа Toyota Land Cruiser 200, RAV-4 маркийн хоёр машинтай, өөрийнх нь жилийн орлого 24 сая бол гэр бүлийнх нь орлого 48 сая, 20 үхэртэй, хурдан удмын 16 адуутай, хоёр га газартай, 25 саяын үнэ бүхий үнэт эдлэлтэй, 50 орчим сая төгрөгийн хадгаламжтай, 100 сая төгрөгийн зээлтэй, “Ю Си Эс” компанийн 250 ширхэг хувьцааг эзэмшдэг хэмээн дурьджээ. Түүний талаар өгүүлэх зүйл одоохондоо иймл л байна. Мэргэжлийн Засгийн газрын томилгоо нүдээ олсон эсэхийг цаг хугацаа харуулах юм хойно үүгээр цэглэе.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ДЭЛХИЙ

## Колин Пауэлл Доналд Трампаас нүүр буруулав

АНУ-ын Бүгд найрамдах намын гишүүн, Төрийн нарийн бичгийн дарга асан Колин Пауэлл ирэх сарын 8-нд явагдах Ерөнхийлөгчийн сонгуулиар Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтонд саналаа өгнө гэдгээ илэрхийллээ. Бүгд Найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байгаа бөгөөд нэг намын гишүүд нь түүнээс нүүр буруулах болсон юм. Трампын эмэгтэйчүүдийг зүй бус үгээр гутаан доромжилж буй бичлэг цацагдсанаас хойш бүгд найрамдахчууд удаа дараа түүнийг дэмжихгүй гэдгээ илэрхийлэх болсон. Үүнийг Хиллари Клинтон ч өөрт ашигтайгаар эргүүлж, бизнесмэн эрээс нүүр буруулсан Бүгд Найрамдах намын гишүүдийн саналыг авах чиглэлийг барьж ажиллах болсон байдаг. Тэгвэл Трампаас нүүр буруулагчдын тоог Төрийн нарийн бичгийн дарга асан Колин Пауэлл нэмлээ. Тэрбээр Жорж В.Бушийг АНУ-ын Ерөнхийлөгчөөр ажиллах байх үед Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хашиж байв. Колин Пауэлл нийгмийн цөөнхийнхөн, дүрвэгсэд, эмэгтэйчүүдийг бүдүүлгээр доромжилсон мэдэгдлийг удаа дараа хийж байсан Трампыг "Үндэсний ичгүүр" хэмээн цоллож байсан удаатай билээ.

## Асрах газрын сувилагч найман өвчтөнөө хөнөөжээ

Канадын өндөр настнуудын асрамжийн газрын сувилагч сүүлийн найман жилийн хугацаанд нийтдээ найман хүний амийг бүрэлгэсэн гэх хэрэгт сэжиглэгдэн баривчлагджээ. Албаны эх сурвалжийн мэдээлснээр эдүгээ 49 настай сувилагч Канадын Торонто хотын зах хэсэгт байрлах хоёр өндөр настны асрах газарт 2007 оноос 2015 оныг хүртэлх найман жилийн хугацаанд өвчтөнүүддээ эм өгч, амийг нь бүрэлгэсэн гэх хэрэгт сэжиглэгдсэн байна. Хэргийн хохирогчид 75-96 насны өндөр настнууд байсан аж. Энэ удаагийн хэргийг орон нутгийн цагдаагийн газрын ажилтнууд гаднаас ирсэн мэдээлэлд үндэслэн өнгөрсөн сараас үүсгэн шалгаж эхэлсэн байна. Улмаар сувилагч эмэгтэйг баривчилжээ. Одоогоор сувилагчийн хүн амины хэрэг үйлдэхдээ ашигласан эм нь чухам юу болох, ямар үйлчилгээтэй болох нь тодорхойгүй байгаа ч, асрамжийн газарт маш олон төрлийн эм хадгалагдаж байсан аж.




# ПАК ГЫН ХЕ АРД ТҮМНЭЭСЭЭ УУЧЛАЛТ ХҮСЛЭЭ

Б.ДАВАА

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хе авлигын хэргээр шалгагдаж буй эмэгтэй найзынх нь талаархи баримтууд ар араасаа дэлгэгдэж буйтай холбогдуулан мэдэгдэл хийж, ард түмнээсээ албан ёсоор уучлалт хүсчээ. Тэрбээр орон нутгийн телевизээр мэдэгдэл хийсэн бөгөөд камерын өмнө толгойгоо бөхийлгөн "Ард түмнээсээ хичээнгүйлэн уучлалт хүсч байна" гэж хэлжээ. БНСУ-ын Прокурорууд Ерөнхийлөгч Пак Гын Хегийн найз гэгддэг Чой Сун Силийг улсын Ерөнхийлөгчтэй дотно харилцаатай гэдгээ ашиглан олон тооны компаниудаас өөрийн эзэмшлийн хоёр сандаа их хэмжээний хандив авсан гэх үндэслэлээр шалгаж байгаа ажээ. 1963-1979 онд тус улсыг удирдаж байсан Пак Жон Хегийн төрсөн охин үе залгамжилсан улстөрч гэгддэг Өмнөд Солонгосын анхны эмэгтэй Ерөнхийлөгч Пак Гын Хегийн хувьд авлигын хэргийн дуулианаас зайгаа барихыг хичээж байжээ.

Гэвч энэ сарын 24-ний өдөр телевизийн нэвтрүүлгээр Пак Ерөнхийлөгч өөрийн гараар бичсэн хэд хэдэн бичвэрийг найз Чой Сун Силд илгээж, улмаар хэд хэдэн баримтдаа засвар хийлгэж байсан гэх баримтууддэлгэгджээ. Авлигын хэргийн дуулиан дэгдсэний дараа эх орноосоо зугтсан Чойн албан өрөөнөөс хураасан компьютероос 200 гаруй баримт олдсон бөгөөд үүнд үндэслэсэн баримтууд нэвтрүүлгийн үеэр дэлгэгдсэн байна. Одоогийн байдлаар Пакын найз Чой чухам хаана байгаа нь тодорхойгүй

> ...Авлигын хэргийн дуулиан дэгдсэний дараа эх орноосоо зугтсан Чойн албан өрөөнөөс хураасан компьютероос 200 гаруй баримт олдсон бөгөөд үүнд үндэслэсэн баримтууд нэвтрүүлгийн үеэр дэлгэгдсэн байна. Одоогийн байдлаар Пакын найз Чой чухам хаана байгаа нь тодорхойгүй байгаа ажээ...

байгаа ажээ. Ард түмнээсээ албан ёсоор уучлалт гуйн толгой бөхийлгөсөн Өмнөд Солонгос улсын Ерөнхийлөгч найзынхаа талаар дурсахдаа "Хүнд хэцүү цаг үед тусалж байсан юм. Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны материал, хэлэх үг зэрэгт түүний тусламцааг авч байв. 2013 оны хоёрдугаар сард Ерөнхийлөгчийн албанд томилогдсоноос хойш ч Чойгоос тусламж авч байсан" гэж ярьжээ. Түүнчлэн "Хэд хэдэн удаагийн материалд түүний санаа бодлыг сонсч байсан удаатай. Гэхдээ Ерөнхийлөгчийн туслахыг томилсноос хойш больсон" гэж тайлбарласан байна.

Чой Сун Сил нь Пак Гын Хе Ерөнхийлөгчийн багшаар ажиллаж байсан шашин судлаач Чой Тэ Миний охин юм байна. Ямартай ч, Чой Сун Силийг авлигын хэрэгт холбогдуулан шалгаж эхэлсэн нь Ерөнхийлөгчийн нэр хүндэд санаатайгаар халдах гэсэн оролдлого байж болзошгүй аж. Учир нь хэрэг мандсанаас хойш Пакыг дэмжигчдийн хувь илт буурсан үзүүлэлттэй болж иржээ. БНСУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч энэ сарын 24-ний өдөр одоогийн мөрдөгдөж буй Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн албыг хашиж буй хүн улиран сонгогдож болохуйц нэмэлт өөрчлөлт оруулах саналаа илэрхийлсэн. Гэвч сөрөг хүчнийхэн түүнийг авлигын хэрэгт холбогдсон найзаасаа олон нийтийн анхаарлыг холдуулж, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудалд хэвлэлийнхний анхаарлыг татахыг оролдож байна хэмээн шүүмжилж байв.

## Жендерийн тэгш байдлаар Монгол 58-д жагслаа

Швейцарийн судалгааны байгууллагаас дэлхийн улс орнуудын нийгмийн хөгжил дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендерийн тэгш байдлын талаархи судалгааны дүнг танилцууллаа. Улмаар уг судалгаанд Монгол 58-д жагсчээ. Дэлхийн улс төр, эдийн засгийн салбарын удирдагчид чуулдаг "Давосын чуулган"-ыг зохион байгуулдаг Швейцарийн судалгааны байгууллага "Дэлхийн эдийн засгийн форум" улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд гэсэн дөрвөн салбарын үзүүлэлтэд үндэслэн жил бүр, жендерийн тэгш байдлын судалгааг хийдэг юм. Улмаар энэ оны судалгааныхаа дүнг өчигдөр зарлалаа.

Энэ удаагийн судалгаанд 144 орныг хамруулсан байх бөгөөд жендерийн тэгш байдлаараа Исланд дахин тэргүүллээ. Тус улс найман жилийн турш тасралтгүй тэргүүлсэн үзүүлэлттэй байна. Харин Финланд, Норвеги, Швед зэрэг орнууд удаалжээ. Харин Монгол Улс 58-д бичигдсэн байв. Манай улсын хувьд эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн салбарт өндөр үнэлгээ авсан байсан хэдий ч, улс төрийн салбарт жендерийн ялгаа их гэж үнэлэгджээ. 2006 онд Монгол 42 дугаарт жагсаж байсан юм. Харин Герман 13, Франц 17, Их Британи 20, Америк 45, Хятад 99, ОХУ 75 дугаарт тус тус эрэмбэлэгдсэн байна. Ингээд жендерийн тэгш байдлаар эхний 10-т жагссан улсыг танилцуулъя.




1. Исланд
2. Финланд
3. Норвеги
4. Швед
5. Руанда
6. Ирланд
7. Филиппин
8. Словени
9. Шинэ Зеланд
10. Никарагуа

## Хятадын байгаль орчныг хамгаалах газрын ажилтнууд баривчлагдлаа

БНХАУ-ын эрх баригчид орчны бохирдлын үнэлгээг засварласан гэх үндэслэлээр тус улсын Шаньси мужийн Шиан хотын Байгаль орчныг хамгаалах газрын ажилтнуудыг баривчилжээ. Орон нутгийн "Huashang Bao" гэх сонинд бичсэнээр тэд орчны бохирдлын хэмжилтийн станц дахь ажиглалтын тоног төхөөрөмжийг даавуун утсаар удаа дараа хааж, үнэн бодит мэдээллийг нуун дарагдуулж байсан аж. Улмаар бодит байдлаас хол зөрүүтэй бохирдлын үнэлгээ гаргасан мэргэжилтнүүдийг цагдаагийн газраас шалгаж эхэлжээ. Орчны бохирдол хэмжих станцын захирал, орлогч, ЧангАн дүүргийн байгаль орчны байцаагчид эдүгээ цагдаагийн газарт саатуулагдсан аж. Агаарын бохирдол Хятадын эрх баригчдын санаа зовоосон асуудлын нэг бөгөөд бүх хотын удирдлагуудад утааг бууруулах чиглэл өгсөн байдаг аж. Улмаар утааг бууруулах зорилтоо биелүүлээгүй албаныханд шийтгэл ногдуулах арга хэмжээ авдаг юм байна.

MMINFO. ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ


# ШУУРХАЙ МЭДЭЭ

## ТӨРИЙН НЭГДСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД ГАДААД ПАСПОРТОО ЗАХИАЛДАГ БОЛНО

Н.БАТЗАЯА

*Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүүгээс гадаад паспорттой холбоотой асуудлаар зарим зүйлийг тодрууллаа.*

**-Гадаад паспортын үйлчилгээг дүүрэгт шилжүүлнэ гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхүй юу?**

-Монгол Улсын Засгийн газрын 100 хоног болон Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын 75 хоногийн ажлын үр дүн гарч эхэллээ. Юуны түрүүнд энэ хугацаанд хийсэн ажлаа танилцуулъя. Засгийн газрын 100 хоногийн хугацаанд маш олон ажлыг амжуууллаа. Тухайлбал, улсын бүртгэлд 23548 хүн шинээр бүртгэгдэж, Монгол Улсын хүн ам өнөөдрийн байдлаар 3.104.201 мянгад хүрсэн. Мөн 28938 хүүхэд мэндэлж, 5304 өрх айл шинээр гэрлэлтээ батлуулсан байна. Түүнчлэн 57 мянган хүүхэд 16 нас хүрч, иргэний үнэмлэхээ авлаа. Энэ мэтчилэн олон ажлыг хийж, хэрэгжүүлсэн. Засгийн газрын 100 хоногийн хугацаанд гэхэд л 94830 иргэн гадаад паспортын захиалга өгч, авсан байна. Ер нь улс орны гадаад харилцаа хөгжихийн хэрээр манай улсын иргэдийн аялах нь ихэссэн. Тэр дундаа ОХУ, БНХАУ, Солонгос улс руу их зорчиж байна. Үүнтэй холбогдуулан гадаад паспортын хэлтэс маш ачаалал ажилладаг. Тиймээс иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, 100 айл дахь гадаад паспортын хэлтсийн ачааллыг бууруулахын тулд гадаад паспорт сунгуулах үйлчилгээг дүүрэгт шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, харьяа дүүргийнхээ иргэний бүртгэлийн хэлтэст гадаад паспортоо сунгуулах боломжтой.

**-Өнгөрсөн наймдугаар сард гадаад паспортын бэлдэц дууссан гэдэг шалтгааны улмаас нэлээд чирэгдэл үүссэн. Энэ ямар учиртай юм бэ. Одоо хэвийн ажиллаж байгаа юу?**

-Өнгөрсөн саруудад гадаад паспортын бэлдэц хомсдсоны улмаас хэвлэлт саатах үе гарсан. Харин өнгөрсөн наймдугаар сараас төсөв санхүүг шийдэж, бэлдэцийг ХБНГУ-д үргэлжлүүлэн захиалснаар ажил хэвийн явагдаж байна. Гадаад паспортын бэлдэц дууссан нь өмнөх ажилтнуудын хариуцлагагүй байдалтай холбоотой. Тухайн үеийн ажилчдын хариуцлагагүй байдлаас болж гадаад паспортын бэлдэцийг хэвлэдэг Германы компанид хэвлэлтийн зардлаа төлөөгүй байсан учраас гэрээ зогссон юм. Үүний улмаас бэлдэц хомстсон. Бид ажлаа аваад Герман улс руу төлөөлөгч явуулж шинэчилсэн гэрээ байгуулсан. Одоо гадаад паспортын захиалга, хэвлэлт жигдэрсэн.

**-Төрийн нэгдсэн үйлчилгээний цэгүүдэд гадаад паспорт захиалах боломжтой болно гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Тийм. Гадаад паспортын захиалгыг ОӨУБЕГ-ын үйлчилгээний хэлтэст авахаас гадна “Мишээл”, “Драгон”, “Дүнжингарав” гэсэн гурван үйлчилгээний төвд байрлах нэг цонхны үйлчилгээгээр авах боломжтой. Эдгээр төвүүдэд дүүрэг хамаарахгүй гадаад паспортын захиалга авна.

**-Хэзээ хэрэгжиж эхлэх вэ?**

-Арваннэгдүгээр сарын 2-ноос эхлэн дээрх хоёр үйлчилгээг иргэд авах боломжтой. Мөн гадаад паспортыг шинээр захиалахад 7-14 хоног хүлээдэг. Гэхдээ бид иргэдийн дунд эрэлт үүссэн учраас долоо хоногийн хугацаанд олгож байна. Өнөөдрийн байдлаар захиалсан эзэн нь ирж аваагүй 5000 гаруй гадаад паспорт ОӨУБЕГ-ын үйлчилгээний гуравдугаар хэлтэст байна. Тэгэхээр захиалга өгсөн иргэд паспортоо ирж авах хэрэгтэй.

**-Нэгдсэн үйлчилгээний төвд гадаад паспорт захиалахад хугацааны хувьд ямар байх вэ. Удах уу?**

-Үгүй. ОӨУБЕГ-т захиалдаг шиг хугацаанд гарна. Түүнээс өөр газар очсон гээд удаж гарна гэсэн зүйл байхгүй. Хамгийн гол нь бид иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхийн тулд энэ ажлыг зохион байгуулсан.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ГУРВАН НАСТАЙ ХҮҮХДИЙГ ДАЙРЧ ГЭМТЭЭЖЭЭ

Замын цагдаагийн албаны ЖШУХ-т энэ сарын 25-ны өдрийн байдлаар нийтдээ 426 дуудлага, мэдээлэл ирсний 342 нь зам тээврийн ослын дуудлага байжээ. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол 10 бүртгэгдсэн бол 13 хүн хүнд, хөнгөн гэмтсэн аж. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн нутаг Баянхошууны зам, долдугаар хорооны баруун замд “Соната” маркийн авто машины жолооч Б нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон “Киа Бонго” маркийн машинтай мөргөлдөж, жолооч 31 настай Б гэмтжээ. Түүнчлэн, Сүхбаатар дүүргийн нутаг Орбитын зам, Хилчингийн нэгдүгээр гудамжны зургаан тоот хашаанд “Соната” маркийн авто машины жолооч Г нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон явган зорчигч гурван настай эрэгтэй Ө-г гэмтээсэн байна. Тиймээс нийт эцэг, эхчүүдэд бага насны хүүхэддээ тавих анхаарлаа сайжруулах, мөн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодохгүй байхыг Замын цагдаагийн газраас анхааруууллаа.

## Б.Баатарцол, Б.Ганзориг нар допинг хэрэглэсэн нь тогтоогджээ

Үндэсний их баяр наадмын дараа шөвгөрсөн бөхчүүдээс допингийн шинжилгээ авдаг уламжлалтай болоод хэдэн жилийн нүүрийг үзэж байгаа. Жил бүр л аль нэг бөх допингийн шинжилгээнд бүдэрч, барилдах эрхээ түр хасуулж, чимэг, цолоо хураалгадаг. Зарим нь допингийн шинжилгээний хариутай эвлэрэхгүй, маргаан үүсгэж, Бөхийн холбооны нөхдүүдийн булхайг уудалж байсан ч удаа бий. Тэгвэл энэ жил ч гэсэн допингийн асуудал дахиад л гарлаа. Наадмын дараа хоёр бөхөөс допинг илэрсэн тухай мэдээлэл гарч эхэлсэн. Тэгэхдээ эцсийн хариу гартал нэрийг нь нууцалж байсан юм. Харин “В” сорьцын шинжилгээний хариу гарч, Улсын начин Б.Баатарцол, Б.Ганзориг нар допинг хэрэглэсэн нь тогтоогдсон байна. Допингийн эсрэг үндэсний төвөөс гаргасан албан ёсны мэдэгдэлд “Их Монгол Улс байгуулагдсаны 810, Ардын Хувьсгалын 95 жилийн ойн Үндэсний их баяр наадамд барилдсан шөвгийн 32 бөх, харваачдаас Үндэсний их баяр наадмын хуулийн дагуу допингийн шинжилгээ авч, БНСУ-ын Шинжлэх ухаан техникийн институтын /KIST/ Допингийн хяналтын лабораторид шинжлүүлсэн билээ. Тус лабораториос 2016 оны наймдугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн шинжилгээний хариуд 3940625 дугаартай Баян-Өлгий аймгийн харъяат Батчулуун овогтой Баатарцол, 3939453 дугаартай Увс аймгийн харьяат Бадрах овогтой Ганзориг нарын “А” сорьцны дээжинд хориотой эмийн жагсаалтад багтах бодис илэрч, допингийн эсрэг дүрмийг зөрчсөн болох тухай манайд мэдэгдсэн. Лабораторийн албан ёсны хариуг холбогдох газруудад дүрмэнд заасан хугацаанд нь бид хүргүүлсэн. Үндэсний бөхийн холбоо болон дээрх хоёр бөхөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу “В” сорьцын шинжилгээ хийлгэх хүсэлтийг БНСУ-ын Шинжлэх ухаан техникийн институтын /KIST/ Допингийн хяналтын лабораторид 2016 оны 8-р сарын 29-ний өдөр уламжилсны дагуу тус байгууллагаас 2016 оны аравдугаар сарын 11-ний өдөр ирсэн “В” сорьцын шинжилгээний хариу нь “А” сорьцын шинжилгээний хариутай ижил гарсан болохыг мэдэгдлээ” гэсэн байв.

## Э.Содномпилжээг “Энсада Холдинг” компани хоёр өрөө байраар урамшуулав

“Рио-2016” олимпийн наадамд паралимпийн пауэрлифтингийн төрөлд монголчууд анх удаагаа тамирчнаа сойсон билээ. Пауэрлифтингийн төрлийн 88 кг-ын жинд хүч үзсэн олон улсын хэмжээний мастер Э.Содномпилжээ 210 кг-г өргөж олимпийн наадмаас хүрэл медаль хүртэж, элэг нэгтнүүдээ баярлуулсан. Хүн төрөлхтөний их наадмаас медаль хүртээд ирсэн тамирчнаа манайхан шагнаж урамшуулдаг уламжлалтай ч ганцхан Э.Содномпилжээг мартсан мэт өнгөрсөн хугацаанд нам гүмхэн байсан билээ. Тиймээс цахим орчинд хэсэг залуус түүнд байр бэлэглэх аян зарлаад удаагүй байхад “Энсада Холдинг” компани “Алтай” хотхонд 47 мкв хоёр өрөө байраар түүнийг шагнах болсноо зарласан.



Тэгвэл өчигдөр шинэхэн байрны түлхүүрийг Э.Содномпилжээд гардуулан өглөө. “Энсада Холдинг” компанийн ерөнхий захирал Ө.Болдсайхан олимпийн медальт тамирчныг гэр бүл найз нөхдийнх нь хамт хүлээн авч уулзсан юм. Э.Содномпилжээ байрныхаа түлхүүрийг гардахаар ээж Н.Амаржаргал болон хүүтэйгээ, мөн цахим ертөнцөд байртай болгох аян өрнүүлсэн Г.Дамбадаржаа, найз МУСТА Э.Найдандорж нарын хамт ирсэн байв. “Энсада Холдинг” компанийн ерөнхий захирал Ө.Болдсайхан “Э.Содномпилжээ маань хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч өмнөө таарсан бүх л саадыг туулж цэнгэлийн манлай олимпийн наадмаас медаль хүртсэн. Энэ нь миний үр хүүхэд болоод бидний хойч үед хүн хичээвэл юунд ч хүрч болдогийг үлгэрлэсэн маш том оюуны хөрөнгө оруулалт болсон. Иймч учраас байраар шагнахаар шийдсэн. Энэ бол миний хувийн шагнал биш, манай компанийн 200-аад ажилтны сэтгэл шингэсэн бэлэг юм шүү. Одоо Э.Содномпилжээ минь ар гэртээ санаа зоволтгүй бэлтгэлээ сайн хийгээрэй. 2020 оны олимпоос алтан медаль хүртвэл гурван өрөө байраар мялаана” гэж амлалаа.

PHOTO NEWS



*Улаанбаатар хотын 377 жилийн ойг угтан нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын нэрэмжит нийслэлийн аварга шалгаруулах өсвөрийн шатарчдын “Их нүүдэл” уламжлалт тэмцээнд өчигдөр эхэллээ. Тэмцээн гурван үе шаттайгаар зохион байгуулагдах бөгөөд есөн дүүргээс шалгарсан 17 багийн 408 хүүхэд оюун ухаан, авхаалж самбаагаа уралдуулан өрсөлдөж байна. “Их нүүдэл” тэмцээн хоёр өдрийн хугацаанд үргэлжилж, шилдгүүд өнөөдөр тодорно.*



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## “Залуу хүн” цуврал лекцийн зочноор Д.Отгондалай уригджээ

Сүүлийн үед оюутан залуучуудын очих, сонсох дуртай лекцүүдийн нэг нь МЗХ-оос зохион байгуулж буй “Залуу Хүн” цуврал болоод байна. Өнгөрсөн долоо хоногт Шивээ-Овоогийн уурхайчин залуустаа “ Гэр бүлийн үнэ цэнэ”, “Ажлын бүтээмж” гэсэн сэвдүүдээр сонирхолтой лекц хүргэсэн бол энэ долоо хоногийн зочноор “Рио-2016” наадмын олимпийн хүрэл медальт, ОУХМ Д.Отгондалай уригджээ.Тэрбээр энэ удаад бага нас, спорттой холбогдсон замнал, Олимпийн хүнд тулаануудынхаа тухай болоод залуу хүнийнхээ үзэл бодлоос хуваалцаж тун сонирхолтой чөлөөт ярилцлага өрнүүлэх гэнэ.
Уг лекц залууст нээлттэй бөгөөд залуус өөрийн хүссэн асуултаа асууж, азтай үзэгч болох боломж ч байгаа аж. Лекц энэ сарын 28-нд МЗХ-ны Залуус танхимд 17:00 цагт эхлэх юм байна.

